



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2017 оны 01 сарын 04 өдөр

Дугаар 4/05

Улаанбаатар хот

Г

Өрхийн эрүүл мэндийн төвийн
гүйцэтгэлийн гэрээний загвар
батлах тухай

Г

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2, Эмнэлгийн тусlamж, үйлчилгээний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Өрхийн эрүүл мэндийн төвтэй байгуулах гүйцэтгэлийн гэрээний загвар”-ыг нэгдүгээр, “Гэрээг дүгнэх журам”-ыг хоёрдугаар, “Гэрээг дүгнэх шалгуур үзүүлэлт”-ийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Өрхийн эрүүл мэндийн төвтэй гэрээ байгуулж, талуудын гэрээний хэрэгжилтэд явцын хяналт хийх, хагас бүтэн жилээр дүгнэж, үр дүнг тооцож ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг даргад зөвлөж, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нарт үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд мэргэжил аргазүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Бодлого төлөвлөлтийн газар /Д.Төмөртогоо/, Эмнэлгийн тусlamжийн газар /Я.Буянжаргал/, Ерөнхий мэргэжлийн салбар зөвлөл /С.Сонин/ нарт даалгасугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Д.Очирбат/-д даалгасугай.
5. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2013 оны 07 сарын 30-ны өдрийн 266 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

САЙД



А.ЦОГЦЭЦЭГ

Эрүүл мэндийн сайдын
2017 оны 01 сарын 01-ны өдрийн
4/05 дугаар тушаалын 1 дүгээр
хавсралт

БАТЛАВ

ЗАХИАЛАГЧ:

АЙМАГ/НИЙСЛЭЛИЙН
ЗАСАГ ДАРГА

АЙМАГ/ НИЙСЛЭЛИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН
ГАЗРЫН ДАРГА

ГҮЙЦЭТГЭГЧ:

ӨРХИЙН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА

/ГАРЫН ҮСЭГ, ТАМГА/

/ГАРЫН ҮСЭГ, ТАМГА/

/ГАРЫН ҮСЭГ, ТАМГА/

ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВТЭЙ БАЙГУУЛАХ
ГҮЙЦЭТГЭЛИЙН ГЭРЭЭ

он сар өдөр
Улаанбаатар хот

Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь заалтыг үндэслэн нэг талаас
нөгөө талаас нар нь аймаг,
нийслэл/дүүргийн дүгээр хороо, багийн үйлчлэх хүрээний хүн амд төрөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэхийг харилцан тохиролцож
оны сарын ний өдөр энэхүү ГЭРЭЭГ /цаашид “гэрээ” гэх/ нэг жилийн хугацаатай байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

- Энэхүү гэрээний зорилго нь: өрхийн эрүүл мэндийн төв /цаашид төв гэх/ -өөс үйлчлэх хүрээний хүн амд төрөөс үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанартай, тэгш, хүртээмжтэй, тасралтгүй үзүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.
- Гэрээнд захиалагч нь аймаг, нийслэлийн Засаг дарга, Эрүүл мэндийн газар, гүйцэтгэгч нь өрхийн эрүүл мэндийн төв байна.
- Талууд гэрээгээр заасныг харилцан зөвшөөрч, үр бүтээлтэй, шударга ажиллах зарчмыг баримтлан гэрээг үйлдэв.

4. Талууд гэрээгээр хүлээсэн үүргийг бүрэн биелүүлэх талаар харилцан шаардлага тавих, үүргээ биелүүлэхгүй нөхцөлд хариуцлага хүлээх асуудлаар тэгш эрх эдэлнэ.

5. Хүн амд үзүүлэх тусламж, үйлчилгээг чанартай, хүртээмжтэй үзүүлсэн тохиолдолд тухайн төвийг шагнаж, урамшуулах ба тусламж, үйлчилгээ доголдсон тохиолдолд гэрээг талуудын саналаар хугацаанаас нь өмнө цуцална.

Хоёр. Гэрээ байгуулах талууд

2.1 Гэрээнд захиалагч байгууллагыг төлөөлж, аймаг, нийслэлийн Засаг дарга, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга байна.

2.2 Гэрээнд гүйцэтгэгч байгууллагыг төлөөлж Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга байна.

Гурав. Гэрээний хугацаа

3.1 Гэрээ нь нэг жилийн хугацаатай байна.

3.2 Гэрээг тухайн оны 01 дүгээр сард багтаан байгуулна.

3.3 Гэрээний биелэлтийг жил бүрийн зургаа, арван хоёрдугаар сарын 25-ны дотор багтаан дүгнэнэ.

Дөрөв. Аймаг, нийслэлийн Засаг даргын эрх, үүрэг

4.1 Аймаг, нийслэлийн Засаг дарга нь дараах үүргийг хүлээнэ.

4.1.1 Төвийг эмнэлгийн зориулалтын байр, засвар үйлчилгээ, дулаан, цахилгаан, цэвэр усаар хангагдах нөхцлийг бүрдүүлэн, төвийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах, төсвийн боломжийг тогтмол зардалд дэмжлэг үзүүлэх,

4.1.2 Төвийн санхүүжилтийг батлагдсан төсвийн дагуу хугацаанд нь тогтмол олгох,

4.1.3 Төвийн санхүү болон үйл ажиллагаанд хяналт тавих, урамшуулах, хариуцлага тооцож ажиллах,

4.1.4 Төвийн үйл ажиллагаанд мэргэжлийн байгууллагуудтай хамтран хяналт үнэлгээ хийх,

4.1.5 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр шаардлага тавих,

4.1.6 Төвийн ашиглаж буй орон нутгийн өмчийн ашиглалт, хамгаалалтад хяналт тавих, шаардлагатай засвар үйлчилгээг хийхэд дэмжлэг үзүүлэх,

4.1.7 Төвийг шаардлагатай эмнэлгийн тоног төхөөрөмж, автомшинаар хангахад дэмжлэг үзүүлэх,

4.1.8 Нутаг дэвсгэрийн хүн амын бүртгэл, хаягжилтыг тодорхой болгон, үйлчлэх хүрээний хүн амын тоог жил бүр тодотгож, шилжилт хөдөлгөөн болон бусад шаардлагатай мэдээллээр улирал тутам хангах,

4.1.9 Тухайн баг, хорооны түр оршин суугч болон бүртгэлгүй иргэдийн судалгааг төвтэй хамтран үнэн зөв гарган, тулгалт хийн баталгаажуулах,

4.1.10 Хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, өвчлөл эндэгдлээс сэргийлэх, хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох зэрэг үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх,

4.1.11 Төвөөс хүн амын эрүүл мэндтэй холбогдуулан тавьсан санал, хүсэлтийг хүлээн авч, холбогдох арга хэмжээг зохион байгуулж хэрэгжүүлэх, эргэн мэдээлэх,

4.1.12 Иргэдийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах, эрүүл зан үйл хэвшүүлэхэд татан оролцуулах, дэмжлэг үзүүлэх,

4.1.13 Онцгой болон өндөржүүлсэн бэлэн байдлын үед ажилласан эмч ажилчдын цалин хөлсийг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу олгуулах, шаардлагатай хөрөнгө санхүүжилтийг аймаг, нийслэлийн засаг даргын нөөц хөрөнгөөс гаргах,

4.1.14 Төвийн эмч, ажиллагдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх, нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлэх.

4.2 Аймаг, нийслэлийн Засаг дарга нь дараах эрхийг эдэлнэ.

4.2.1 Төвөөс иргэдэд чанартай тусlamж, үйлчилгээг тэгш, хүртээмжтэй үзүүлэх талаар шаардлага тавих,

4.2.2 Гамшиг, осол, нийтийг хамарсан өвчин, халдварт өвчний үед өрхийн эрүүл мэндийн төвийг дайчлах, үүрэг даалгавар өгөх,

4.2.3 Төвийн үйл ажиллагааны үр дүн гүйцэтгэлээс хамааран шагнал урамшуулал олгох, холбогдох байгууллагуудад уламжлан шийдвэрлүүлэх,

4.2.4 Гэрээний гүйцэтгэлийг “Бүрэн хангалттай” буюу 90 хувиас дээш үнэлгээтэй биелүүлсэн төвүүдийг шагнаж урамшуулах,

4.2.5 Дараах тохиолдолд гэрээг цуцлах саналаа аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газарт хүргүүлнэ:

4.2.5.1 Гэрээний гүйцэтгэлийг “Хангалтгүй” буюу 69,9 хувиас доош үнэлгээтэй биелүүлсэн,

4.2.5.2 Гэрээний гүйцэтгэлийг дүгнэхэд “Ажил сайжруулах шаарлагатай” буюу 70%-79,9% үнэлгээг дараалан 2 удаа авсан,

4.2.5.3 Хууль эрх зүйн, төрийн ба орон нутгийн өмчийн ашиглалт, хамгаалалттай холбоотой ноцтой зөрчил гаргасан нь тогтоогдсон,

4.2.5.4 Хамт олон багаар ажиллаагүй, даргын хариуцлагагүй үйл ажиллагаанаас үүдэн тусlamж, үйлчилгээ алдагдахад хүрсэн зэрэг ноцтой зөрчил илэрч, нотлогдсон.

Тав. Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын эрх, үүрэг

5.1 Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газарын дарга нь дараах үүргийг хүлээнэ.

5.1.1 Төвийг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, бие даан ажиллах боломж нөхцлийг бүрдүүлэх,

5.1.2 Төвд мөрдөгдөж буй хууль, стандарт, дүрэм, тушаал, журам, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих,

5.1.3 Төвийн үйл ажиллагаатай холбоотой иргэн, байгууллагаас ирүүлсэн санал, хүсэлт, гомдлыг шуурхай барагдуулж, эргэн мэдээллэх,

5.1.4 Төвийн эмч, мэргэжилтнүүдийг цаг үеийн болон мэргэжлийн холбогдолтой мэдээллээр тогтмол хангаж ажиллах,

5.1.5 Төвийг эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах тоног төхөөрөмж, багаж, хэрэгслэл, оношуураар хангахад дэмжлэг үзүүлэх,

5.1.6 Төвд шаардлагатай багаж тоног төхөөрөмжийн зардлыг төсөвт суулган, захиалж хангах,

5.1.7 Төвийн эмч мэргэжилтнүүдийг эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлэх, зөрчлөөс сэргийлэх ажлыг зохион байгуулах,

5.1.8 Хөдөлмөрийн тухай хууль, бусад холбогдох тушаал шийдвэрт нийцүүлэн, гамшиг, онцгой байдал, нийтийг хамарсан халдварт өвчин, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдал үүссэн үед болон нийтээр амрах баярын өдрүүд, бямба гаригт төвийг ажиллуулах тохиолдолд илүү цагийн хөлс олгоход дэмжлэг үзүүлэх,

5.1.9 Төвийн үйл ажиллагааны үр дүн, гүйцэтгэлээс хамааран шагнал урамшуулал олгох, холбогдох байгууллагуудад уламжлан шийдвэрлүүлэх.

5.2 Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нь дараах эрхийг эдэлнэ.

5.2.1 Төвөөс иргэдэд чанартай тусламж, үйлчилгээг тэгш, хүртээмжтэй үзүүлэх талаар шаардлага тавих,

5.2.2 Иргэдийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах, эрүүл зан үйл хэвшүүлэхэд төвийг татан оролцуулах,

5.2.3 Хөдөлмөрийн тухай хууль, бусад холбогдох тушаал шийдвэрт нийцүүлэн, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдал, гамшиг, осол, нийтийг хамарсан халдварт өвчин үүссэн үед болон нийтээр амрах баярын өдрүүд, бямба гаригт төвийг ажиллуулах,

5.2.4 Төвийн үйл ажиллагаанд үнэлгээ хийх, үр дүн, гүйцэтгэлээс хамааран шагнал урамшуулалд тодорхойлох, олгуулах талаар холбогдох байгууллагуудад хандан шийдвэрлүүлэх,

5.2.5 Тухайн жилд гүйцэтгэлийг “Бүрэн хангалттай” буюу 90 хувиас дээш үнэлгээтэй биелүүлсэн төвүүдийг шагнах, үйл ажиллагааг сурталчлах,

5.2.6 Дараах тохиолдолд гэрээг цуцална:

5.2.6.1 Гэрээний гүйцэтгэлийг “Хангалтгүй” буюу 69,9 хувиас доosh үнэлгээтэй биелүүлсэн

5.2.6.2 Гэрээний гүйцэтгэлийг дүгнэхэд “Ажил сайжруулах шаарлагатай” буюу 70%-79,9% үнэлгээг дараалан 2 удаа авсан,

5.2.6.3 Хууль эрх зүйн болон төрийн ба орон нутгийн өмчийн ашиглалт, хамгаалалттай холбоотой ноцтой зөрчил гаргасан нь тогтоогдсон,

5.2.6.4 Хамт олон багаар ажиллаагүй, даргын хариуцлагагүй үйл ажиллагаанаас үүдэн тусламж үйлчилгээ алдагдахад хүрсэн зэрэг ноцтой зөрчил илэрч нотлогдсон.

Зургаа. Өрхийн эрүүл мэндийн төвийн даргын эрх, үүрэг

6.1 Төвийн дарга нь дараах үүргийг хүлээнэ.

6.1.1 Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, Өрхийн эрүүл мэндийн төвийн дүрэмд заасан нийтлэг үүргийг хүлээж ажиллах,

6.1.2 Төвийн бүтэц, үйл ажиллагааны стандарт, тушаал, журам, шийдвэр, заавруудыг мөрдлөг болгож ажиллах, үүрэг даалгаврыг хугацаанд нь чанартай биелүүлэх, тайлагнах,

6.1.3 Төвийн үйл ажиллагааг хэвийн явуулахад зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмж, техник хэрэгслэл, бусад материалаар хангах,

6.1.4 Хүний нөөцийг бүрдүүлэх, дадлагажуулах, хөгжүүлэх, нийгмийн асуудлыг шийдвэрлэх цогц бодлого хэрэгжүүлж, ажлын байрны эрүүл аюулгүй орчин бүрдүүлэх, төвийн эмч, ажилчдын нийтлэг эрх ашгийг хамгаалах,

6.1.5 Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг мөрдөж, мэргэжлийн үүргийг чанд биелүүлж, хамт олон баг бүрдүүлж ажиллах,

6.1.6 Үйлчлэх хүрээний хүн амд тусlamж үйлчилгээний багцад заасан эрүүл мэндийн тусlamж үйлчилгээг чанар, хүртээмжтэй, чирэгдэлгүй, тасралтгүй үзүүлэх,

6.1.7 Үйлчлэх хүрээний иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл аж төрөх зан үйл хэвшүүлэх, мэдээллээр хангах, нийгмийн эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээг хүртээмжтэй хүргэж, үр дүнг тооцох,

6.1.8 Үйлчлэх хүрээний хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх хүчин зүйлсийг арилгах талаар шийдвэр гаргах түвшинд асуудал тавих, шийдвэрлүүлэх,

6.1.9 Үйлчлэх хүрээний хүн амын эрүүл мэндийн асуудлаар төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах,

6.1.10 Үйлчлэх хүрээний хүн амын эрүүл мэндийн үзүүлэлт, орчны байдал, шаардлагатай бусад мэдээллийг иргэдэд мэдээлэх,

6.1.11 Төсөв санхүүгийн холбогдолтой хууль, дүрэм, журмыг чанд сахиж, санхүү хөрөнгийг оновчтой зөв зарцуулж, хамт олон, иргэдэdmэдээлэх,

6.2. Төвийн дарга нь дараах эрхийг эдэлнэ.

6.2.1. Эрүүл мэндийн тухай хууль, Өрхийн эрүүл мэндийн төвийн дүрэмд заасан нийтлэг эрхийг эдлэх,

6.2.2. Төвийн үйл ажиллагааг хэвийн явуулах, тулгамдсан асуудлаа шийдвэрлүүлэх талаар холбогдох байгууллагуудадасуудал тавих, шийдвэрлүүлэх,

6.2.3. Хөдөлмөрийн тухай хууль болон бусад хууль, дүрэм, тушаалыг зөрчсөн аливаа асуудлыг хуулийн дагуу шийдвэрлүүлэх,

6.2.4. Бусад талуудыг гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах,

6.2.4. Батлагдсан санхүүжилт авах, төсвийг батлагдсан хууль дүрэм, журмын дагуу зарцуулах,

6.2.5. Гамшиг, осол, нийтийг хамарсан халдварт өвчин, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдал үүссэн үед, амралт баяр ёслолын үеэр илүү цагаар ажилласан тохиолдолд эмч ажилчдад урамшуулал, илүү цагийн хөлс олгох талаар удирдах байгууллагад хандах, шийдвэрлүүлэх.

Долоо. Санхүүжилт

7.1. Төвийн санхүүжилт нь улсын болон орон нутгийн төсөв, эрүүл мэндийн даатгалын санхүүжилт, нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөрийн санхүүжилт, хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэрээс бүрдэнэ.

7.2. Төвийн санхүүжилтийг “Эмнэлгийн тусlamж, үйлчилгээний тухай” хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх заалтад зааснаар олгоно.

7.3. Нэг иргэнээр тооцсон тарифын хэмжээг тусламж, үйлчилгээний өртөг, үнийн өсөлттэй уялдуулан жил бүр шинэчлэн, тогтоосон жишгийг мөрдөнө.

7.4. Тухайн төвөөр үйлчлүүлсэн хөдөлгөөнт хүн ам, бүртгэлгүй иргэн, түр оршин суугаа иргэдийн сүүлийн 2 жилийн судалгааг үндэслэн тухайн төвд үйлчлүүлсэн иргэдэд эзлэх хувь хэмжээгээр тооцоолж, гүйцэтгэлд үндэслэн, тохиололд суурилсан төлбөрийн аргаар бодож олгоно.

7.5. Иргэний эрүүл мэндийн даатгалаас санхүүжүүлэхээр тогтоосон тусламж, үйлчилгээг үзүүлсэн тохиолдолд эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжилт олгоно.

7.6. Санхүүгийн зөрчил гарсан тохиолдолд холбогдох хуулийн дагуу хариуцлага тооцно.

Найм. Төрийн өмчийн хөрөнгийн бүртгэл, ашиглалт

8.1. Төв нь аймаг, нийслэлийн өмчийн харилцааны газартай “Өмч эзэмших гэрээ” байгуулан, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж ажиллана.

8.2. Төвд ашиглагдаж буй өмч, хөрөнгийн тооллогыг жилд 2 удаа хийнэ.

8.3. Төв нь төрийн болон орон нутгийн өмч хөрөнгийг холбогдох байгууллагын зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдийн эзэмшил, ашиглалтанд шилжүүлэхийг хориглоно.

8.5. Төвийн их засварыг хугацаанд нь орон нутгийн төсвөөр хийж гүйцэтгэнэ.

8.6. Төв нь төрийн болон орон нутгийн өмч, хөрөнгийг үрэгдүүлж, шамшигдуулсан, зориулалтын бусаар ашигласан нь нотлогдсон тохиолдолд дүрмийн 5.2.6.3-д заасны дагуу болон холбогдох хууль, журмын дагуу хариуцлага хүлээнэ.

Ес. Тайлagnaх үйл ажиллагаа

9.1. Төв нь үйл ажиллагааны тайланг хагас бүтэн жилээр гарган аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газарт хүргүүлнэ.

9.2. Төв нь төвд ногдох иргэний статистик тоог хагас жил тутамд гарган аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газарт хүргүүлнэ.

9.3. Аймаг, нийслэлийн Засаг даргын захирамжаар гүйцэтгэлийн гэрээний биелэлтийг үнэлэх ажлын хэсэг гэрээг дүгнэнэ.

9.4. Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар нь гэрээний биелэлт, өрхийн эрүүл мэндийн төвийн тусламж, үйлчилгээний талаар зөвлөмж боловсруулан, байгууллагын цахим хуудсанд жил бүрийн 2 дугаар сард багтаан байршуулна.

9.5. Санхүүгийн тайланг “нэгтгэсэн санхүүгийн тайлан ба хяналтад байгаа байгууллагын нягтан бодох бүртгэл” стандартын дагуу тайлангийн нэгтгэлд хамруулна.

Арав. Гэрээ шууд цуцлах

10.1. Төв нь гэрээнд заасан ажил, үйлчилгээг гүйцэтгээгүй тохиолдолд захиалагчийн санаачилгаар гэрээг шууд цуцална.

10.2. Төв нь гэрээнд заасан ажил, үйлчилгээг гүйцэтгэхээс татгалзсан тохиолдолд гэрээг шууд цуцална.

10.3. Гэрээ цуцалсан тохиолдолд дараагийн төвийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулах хүртэл хугацаанд тусламж, үйлчилгээг тасралтгүй явуулах үүргийг урьд гэрээтэй байсан өрхийн эрүүл мэндийн төв гүйцэтгэнэ.

Арван нэг. Маргаан шийдвэрлэх

11.1. Энэ гэрээнд заагдаагүй аливаа асуудлыг Монгол улсад дагаж мөрдөж буй хууль, тогтоомжоор зохицуулна.

11.2. Талууд гэрээтэй холбоотой үүргээ биелүүлээгүй гэж үзвэл асуудлыг холбогдох дээд шатны болон хяналтын байгууллагад тавьж, шийдвэрлүүлнэ.

11.3. Гэрээтэй холбоотой маргааныг талууд ойлголцож, харилцан тохиролцо замаар шийдвэрлэж болно.

Арван хоёр. Бусад зүйл

12.1. Талууд энэхүү гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ аль нэг талын албан ёсны зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд хэсэгчилэн буюу бүрэн хэмжээгээр шилжүүлэхийг хориглоно.

12.2. Гүйцэтгэлийн гэрээг захиалагч, гүйцэтгэгч талуудын оролцоотой жил тутам дүгнэж, цаашид гэрээг сунгах, цуцлах, өөрчлөлт оруулах асуудлыг шийдэж баталгаажуулна.

12.3. Гэрээг сунгасан тохиолдолд тэмдэглэл үйлдэн, сунгалтын хамт гэрээнд хавсаргана.

12.4. Гэрээг жил бүрийн 01 дүгээр сард багтаан байгуулж, 3 хувь үйлдэн талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болж мөрдөгднө.

ГЭРЭЭНИЙ ТАЛУУД:

Аймаг, нийслэлийн
Засаг даргын тамгын
газрыг төлөөлж:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг]_____

ТАМГА

Аймаг, нийслэлийн ЭМГ-ыг
төлөөлж:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг]_____

ТАМГА

Өрхийн
төлөөлж:
ЭМТ-ийг

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг]_____

ТАМГА

Эрүүл мэндийн сайдын
2017 оны 01 сарын 04-ны өдрийн
Аюудугаар тушаалын 2 дугаар
хавсралт

ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВТЭЙ БАЙГУУЛАХ ГҮЙЦЭТГЭЛИЙН ГЭРЭЭГ ДҮГНЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Өрхийн эрүүл мэндийн төвөөс хүн амд үзүүлэх эмнэлгийн болон нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг чанартай, тэгш, хүртээмжтэй, тасралтгүй үзүүлэх, өрхийн эрүүл мэндийн төвийн тогтвортой байдлыг хангах, олон улсын жишигт нийцсэн төв болгон хөгжүүлэхтэй холбоотой байгуулсан гэрээг үнэлж дүгнэхэд оршино.

1.2. Гэрээний захиалагч тал Эрүүл мэндийн сайдын тушаалыг үндэслэн аймаг, нийслэлийн Засаг дарга, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга, гүйцэтгэгч тал Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нарын хамтран байгуулсан гүйцэтгэлийн гэрээний биелэлтийн үр дүнг үнэлэхэд энэхүү журмыг баримтална.

Хоёр. Гэрээг дүгнэхэд баримтлах зарчим

2.1. Монгол улсын хууль, тогтоомж, холбогдох дээд шатны байгууллага, эрх бүхий албан тушаалтнаас гаргасан бүтэц, үйл ажиллагааны стандарт, тушаал, журам, заавар, шийдвэр, урт болон дунд хугацааны төлөвлөлт, хөтөлбөрийг баримтлан ил тод, шуурхай, нээлттэй, хамт олны оролцоог хангасан байна.

2.2. Гэрээний гүйцэтгэлийг дүгнэх аргачлал хэмжигдэхүйц, бодитой, ажлын ачааллыг харгалзсан, ойлгомжтой, тодорхой үр дунд үндэслэсэн байна.

Гурав. Гэрээг дүгнэх ажлын зохион байгуулалт

3.1. Гэрээний биелэлтийг жил бүрийн зургаа, арван хоёрдугаар сарын 25-ны дотор багтаан дүгнэж, дүнг ажлын хэсгийн хурлаар хэлэлцэн, баталгаажуулна.

3.2. Гэрээний талуудын төлөөлөл бүхий ажлын хэсэг гэрээний биелэлтийг дүгнэнэ. Ажлын хэсэг дараах 11 хүний бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

3.2.1. Ажлын хэсгийн ахлагч: Аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн хөгжлийн/бодлогын хэлтсийн дарга/ ЗДТГ-ын Эрүүл мэндийн асуудал хариуцсан түшмэл/

3.2.2. Гишүүдэд:

3.2.2.1 Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын Санхүүгийн хэлтсийн мэргэжилтэн,

3.2.2.2 Аймаг, нийслэлийн ЭМГ-ын Анхан шатны тусламж, үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн,

3.2.2.3 Аймаг, нийслэлийн ЭМГ-ын Чанарын асуудал хариуцсан мэргэжилтэн

3.2.2.4 Аймаг, нийслэлийн ЭМГ-ын Халдварт өвчний асуудал хариуцсан мэргэжилтэн

3.2.2.5 Аймаг, нийслэлийн ЭМГ-ын Эх барих, эмэгтэйчүүдийн асуудал хариуцсан мэргэжилтэн

3.2.2.6 Аймаг, нийслэлийн ЭМГ-ын Хүүхэд, өсвөр үеийн эрүүл мэндийн асуудал хариуцсан

3.2.2.7 Аймаг, нийслэлийн ЭМГ-ын Сувилахуйн тусlamж, үйлчилгээ хариуцсанмэргэжилтэн

3.2.2.8 Монголын өрхийн анагаах ухааны мэргэжилтнүүдийн холбооны төлөөлөл

3.2.2.9 Иргэний төлөөлөл

3.2.3 Нарийн бичгийн дарга: Аймаг, нийслэлийн ЭМГ-ын Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга

Дөрөв. Гэрээний биелэлтийг дүгнэх арга аргачлал

4.1 Гэрээний биелэлтийг шалгуур үзүүлэлтүүдийн дагуу хагас жил тутамд 1 удаа, жилд нийт 2 удаа дүгнэж, 2 дүнгийн дундгийг жилийн эцсийн гэрээний биелэлтийн дүн гэж тооцно.

4.2 Ажлын хэсэг холбогдох байгууллагуудаас шаардлагатай мэдээ, мэдээллийг цуглуулж, төвийн эмч ажилчид, иргэдээс сэтгэл ханамжийн судалгаа авч, жилийн турш хийгдсэн ажлын явцын үнэлгээний дүнг ашиглан гэрээнийбиелэлтийг дүгнэнэ.

4.3 Аймаг, нийслэлийн Засаг дарга, Эрүүл мэндийн газрын даргын гэрээний биелэлтийг шалгуур үзүүлэлтийн дагуу дүгнэнэ.

4.4 Өрхийн эрүүл мэндийн төвийн гэрээг дүгнэх шалгуур үзүүлэлт нь үндсэн 3 хэсгээс бүрдэх ба удирдлага зохион байгуулалт нийт үнэлгээний 24 хувь, эмнэлгийн тусlamж, үйлчилгээ 47 хувь, нийгмийн эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээ 29 хувь тус эзлэх ба онооны дагуу хувьд шилжүүлэн тооцно.

4.5 Ажлын хэсгийн гишүүд гэрээг ΘЭМТ-ийн ажлын байранд дүгнэнэ.

4.6 Тоогоор илэрхийлэх боломжгүй зорилтын шалгуур үзүүлэлтийн биелэлтийн хувийг дараах зарчмаар үнэлнэ. Үүнд:

4.6.1 Тавьсан зорилтдоо бүрэн хүрсэн, энэ талаар холбогдох шийдвэр гарч, үр дүн гарсан бол гүйцэтгэлийг 90-100 хувьбуюу 5 оноо,

4.6.2 Тавьсан зорилтдоо бүрэн хүрээгүй боловч санхүү, зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, холбогдох шийдвэр гарсан, гол үр дүн гарч эхлэж байгаа бол гүйцэтгэлийг 80-89,9 хувь буюу 4 оноо,

4.6.3 Тавьсан зорилтонд хүрэх зорилгоор өөрсдөөс хамаарах шийдвэрийг гаргасан, санхуугийн асуудал шийдвэрлэгдсэн, дээд шатны байгуулагад өргөн барьсан ба гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа бол гүйцэтгэлийн 70-79,9 хувь буюу 3 оноо,

4.6.4 Тухайн зорилтыг хэрэгжүүлэх бэлтгэл болон боловсруулалтын шатны ажил бүрэн хийгдсэн ажил тодорхой хэмжээнд эхэлсэн бол хийгдэж байгаа ажлын түвшинг харгалзан гүйцэтгэлийг 60-69,9 хувь буюу 2 оноо,

4.6.5 Тухайн зорилтыг хэрэгжүүлэх бэлтгэл ажил хийгдэж дуусаад боловсруулалтын шатанд байгаа бол гүйцэтгэлийг 50-59,9 хувь буюу 1 оноо,

4.6.6 Тухайн зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай тооцоо судалгаа хийх, асуудал тодорхойлох зэрэг бэлтгэл хангахтай холбоотой арга хэмжээг авч эхэлж байгаа болон ажил хэрэгжүүлэх талаар ямар ч ажил эхлээгүй бол гүйцэтгэлийг 49-өөс доош хувь буюу 0 оноо гэж үзнэ.

4.7 Ерөнхий үнэлгээний дүнг дараах байдлаар дүгнэнэ.

№	Үнэлгээ	Бүрэн хангалттай 90%-100%	Хангалттай 80%-89,9%	Ажил сайжруулах шаардлагатай 70%-79,9%	Хангалтгүй 69,9% хүртэл
1	Удирдлага зохион байгуулалт	76-85 оноо	68-75 оноо	59-67 оноо	58-аас доош оноо
2	Эмнэлгийн тусlamж, үйлчилгээ	148-165 оноо	132-147 оноо	115-131 оноо	114-өөс доош оноо
3	Нийгмийн эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээ	90-100 оноо	80-89 оноо	70-79 оноо	69-өөс доош оноо

Тав. Гэрээний биелэлтийн үнэлгээг баталгаажуулах

5.1 Гэрээний биелэлтийг дүгнэх “Илтгэх хуудас”-нд талууд тус тусын гарын үсгийг зурж, эрх бүхий этгээд тамга, тэмдэг дарж баталгаажуулснаар үнэлгээ хүчин төгөлдөр болно.

5.2 “Илтгэх хуудас”-ыг 3 хувь үйлдэж холбогдох байгууллагууд тус тус авна.

5.3 Гүйцэтгэлийн гэрээг захиалагч, гүйцэтгэгч талуудын оролцоотой жил тутам дүгнэж, цаашид гэрээг сунгах, цуцлах, өөрчлөлт оруулах зэрэг асуудлыг шийдэж баталгаажуулна.

Зургаа. Гэрээний биелэлтийг нэгтгэн дүгнэсэн үнэлгээний мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээ

6.1 Гэрээний биелэлтийг дүгнэсэн үнэлгээг үндэслэн Эрүүл мэндийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, эрх зүйн актыг тус тус үндэслэн дор дурдсан арга хэмжээг авна.

6.1.1 Захиалагч нь “Ажил сайжруулах шаардлагатай” үнэлгээтэй дүгнэгдсэн төвтэйгэрээг хагас жилээр байгуулан, хугацаатай үүргийг өгч, биелэлтийг тооцон ажиллана.

6.1.2 Гүйцэтгэгч нь “Ажил сайжруулах шаардлагатай” үнэлгээгээр дараалан 2 удаа үнэлгэдсэн тохиолдолд захиалагч гэрээг цуцална.

6.1.3 Тухайн жилд “Хангалтгүй” үнэлгээ авсан төвийн гэрээг шууд цуцална.

6.1.4 Тухайн жилд зөвхөн удирдлага зохион байгуулалтын үйл ажиллагаа “Хангалтгүй” үнэлгээтэй дүгнэгдсэн төвийн даргыг солих саналыг хамт олонд хүргүүлж, шийдвэрлүүлнэ.

6.1.5 Тухайн жилд зөвхөн эмнэлгийн тусlamж, үйлчилгээний үйл ажиллагаа “Хангалтгүй” үнэлгээтэй дүгнэгдсэн төвтэй гэрээг хагас жилээр байгуулан, эмнэлгийн тусlamж үйлчилгээг сайжруулах хугацаатай үүргийг өгч, биелэлтийг тооцон ажиллана.

6.1.6 Тухайн жилд үндсэн З үзүүлэлтэд “Бүрэн хангалттай” үнэлгээтэй дүгнэгдсэн төвийг “Нэгдүгээр зэрэглэлийн өрхийн эрүүл мэндийн төв” болгон зарлаж, шагнаж урамшуулна.

6.2 Гэрээний үүргээ хангалтгүй биелүүлсэн аймаг, нийслэлийн Засаг дарга, Эрүүл мэндийн газрын дарга наарт хариуцлага тооцох саналыг ажлын хэсгийн зүгээс харьяалах дээд шатны байгууллагад уламжлан, шийдвэрлүүлнэ.

Эрүүл мэндийн сайдын
2017 оны 01 сарын 04-ны өдрийн
Агаар тушаалын З дугаар
хавсралт



**ӨРХИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ГЭРЭЭГ
ДҮГНЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ**

**Нэг. Аймаг, нийслэлийн Засаг даргын гүйцэтгэлийн гэрээг
дүгнэх шалгуур үзүүлэлт**

№	Шалгуур үзүүлэлт	Оноо
1	Гэрээнд заасан хугацаанд санхүүжилтийг олгож, гэрээг дүгнэж ажилласан бол /санхүүжилт олгосон хугацааг харуулах баримт, гэрээг дүгнэж үнэлсэн дүгнэлт/	10
2	Төвийг зориулалтын байр, дулаан, цахилгаан, цэвэр усаар хангдах нөхцлийг бүрдүүлж ажилласан бол /энэ талаар гарсан гомдол саналын тоо, шийдсэн арга хэмжээний баримт, хуваарилж олгосон санхүүжилт, бодит хэрэгжүүлсэн ажил/	10
3	Хороодын нутаг дэвсгэрийн хүн амын бүртгэл, хаягжилтыг тодорхой болгон, хүн амын шилжих хөдөлгөөн бусад шаардлагатай мэдээллээр хангаж ажилласан бол /улирал тутамд шинэчлэн ирүүлсэн мэдээг харуулах баримт/	10
4	Түр оршин суугчдын асуудлыг шийдвэрлэж, хамтран ажилласан бол /албан ёсны баримт бүртгэлийгирүүлсэн байдал/	10
5	Төвийн санал, хүсэлтийг шийдвэрлэж, эргэн мэдээллэж, түүний мөрөөр арга хэмжээ авсан бол /шийдвэрлэсэн тухай баримт, албан тоот/	10
6	Төвийн эмч мэргэжилтнүүдийг сургах, мэргэжил дээшлүүлэх, туршлага судлах зэрэг үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлсэн бол /төлөвлөгөөний дагуу сургасан эмч, мэргэжилтнүүдийн тоо, олгосон санхүүгийн дэмжлэг/	10
7	Төвийн эмч мэргэжилтнүүдийн нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлж ажилласан бол /дэмжлэгийн тоо, албанбаримт/	10
8	Төвийн үйл ажиллагааны үр дүн гүйцэтгэлээс хамааран гэрээнд заасан шагналурамшууллыг олгож, хариуцлага тооцсон байдал /албажуулсан баримт/	10

9	Төвийн засвар үйлчилгээ, орчны тохижилтонд дэмжлэг үзүүлж ажилласан бол /бодит хөрөнгө оруулалтыг харуулсан баримт/	10
10	Иргэдийг өвчнөөс урьдчилан сэргийлэх эрт илрүүлэгийнүзлэг шинжилгээнд хамруулах ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж ажилласан бол /хамтран хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, журам, тушаал, шийдвэрийн хэрэгжилтийг хангулсан бичиг баримт/	10

**Хоёр. Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын
гүйцэтгэлийн гэрээг дүгнэх шалгуур үзүүлэлт**

№	Үзүүлэлт	Оноо
1	Аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын холбогдох мэргэжилтнүүд төвийг мэргэжил арга зүйгээр хангаж ажилласан байдал 1. Мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан байдал - 3 оноо 2. Төвийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хамтарч ажилласан бол- 2 оноо	
1.1	Анхан шатны тусlamж, үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн	5
1.2	Хүүхэд, өсвөр үеийн эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн	5
1.3	Эх барих, эмэгтэйчүүдийн асуудал хариуцсан мэргэжилтэн	5
1.4	Халдварт өвчний асуудал хариуцсан мэргэжилтэн	5
1.5	Сувилахуйн тусlamж, үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн	5
1.6	Чанарын асуудал хариуцсан мэргэжилтэн	5
2	Төвийн үйл ажиллагааг дэмжиж ажилласан бол	15
3	Төвийн эмч, мэргэжилтнүүдийг цаг үеийн болон мэргэжлийн холбогдолтой мэдээллээр тогтмол хангаж ажилласан бол	10
4	Төвийг эмнэлгийн тусlamж, үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах тоног төхөөрөмж, багаж, хэрэгслэл, оношлуураар хангахад дэмжлэг үзүүлсэн бол	10
5	Төвийн эмч мэргэжилтнүүдийг эмнэлгийн мэргэжилтний ёс зүйнхэм хэмжээг мөрдөх, харилцааны зөрчлөөс сэргийлэх ажлыг зохион байгуулсан бол	10
6	Хөдөлмөрийн тухай хууль, бусад холбогдох тушаал шийдвэрт нийцүүлэн, гамшиг, онцгой байдал, нийтийг хамарсан халдварт өвчин, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдал үүссэн үед болон нийтээр амрах баярын өдрүүд, бямба гаригт төвийг ажиллуулах тохиолдолд илүү цагийн хөлс олгоход дэмжлэг үзүүлсэн бол	10

7	Tөвийн үйл ажиллагааны үр дүн, гүйцэтгэлээс хамааран шагнал урамшуулалт олгох, холбогдох байгууллагуудад уламжлан шийдвэрлүүлсэн бол	15
---	--	----

Гурав. Өрхийн эрүүл мэндийн төвийн гүйцэтгэлийн гэрээг дүгнэх шалгуур үзүүлэлт

№	Үзүүлэлт	Үнэлэх аргачлал	Оноо	
Нэг. Удирдлага, зохион байгуулалт, менежерийн манлайлал - 85 оноо				
1	Төвийн жил, улирлын үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт	95%-иасдээш бол - 5 оноо 90%-95% бол - 4 оноо 85%-90% бол - 3 оноо 80%-85% бол - 2 оноо 75%-80% бол - 1 оноо 75% доош бол - 0 оноо	5 оноо	
	Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээ, эмч, мэргэжилтнүүдийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл	Зөрчилгүй бол - 5 оноо Зөрчилтэй бол - 0 оноо	5 оноо	
	Үйл ажиллагаа тогтмолжсон эсэх	1. Нөхөрлөлийн гишүүдэд эмч, эмнэлгийн ажилчдын 70-аас доошгүй хувь нь элссэн эсвэл компанийн зохион байгуулалттай бөгөөд ТҮЗ-тай ажилласан бол-5 оноо 2. Дотоод журамд тодотгол хийсэн байдал-2 оноо 3. Ажлын байрны тодорхойлолт бүрэн бол -1 оноо 4. Хөдөлмөрийн гэрээг бүрэн байгуулсан бол - 1 оноо 5. Ажилчдын тухайн жилийн гүйцэтгэлийн гэрээний биелэлт, тайлан бүрэн бол - 1 оноо	10 оноо	
2	Хүний нөөцийн удирдлага,	Стандартын дагуу хүний нөөцөөр хангагдсан байдал	Тогтвортой, бүрэн хангагдсан бол- 5 оноо Дутуу орон тоо бүрээс 1 оноо хасах	5 оноо
		Хүний нөөцийг хөгжүүлэх төлөвлөгөөний биелэлт	90%-иасдээш бол -5 оноо 85%- 90% бол - 4 оноо 80%-84% бол - 3 оноо 80%-аас доош бол 0-2 оноо	5 оноо

		Эмч, мэргэжилтнүүдийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийн зөрчилгүй байх	Зөрчилгүй бол- 5 оноо Зөрчил гаргасан нь нотлогдсон бол- 0 оноо	5 оноо
		Мэргэжлийн болон ёс зүйн алдаа гаргаагүй байх	Зөрчил гаргаагүй бол – 5 оноо Зөрчил гаргасан нь ёс зүйн хурлаар нотлогдсон бол – 0 оноо /Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хорооны мэдээлэлд үндэслэх/	5 оноо
3	Байгууллагын мэдээлэл технологийн чадавхи	Дотоод сүлжээ, төвийн цахим хуудастай байх	1. Дотоод сүлжээ ашиглаж хэвшсэн бол - 1 оноо 2. Цахим хуудас тогтмол ажиллуулдаг бол-1 оноо 3. Цахим хуудсанд баяжилт хийдэг, олон нийтийн хандалтын байдал – 1-3 оноо	5 оноо
		Хүн амын бүртгэл судалгааг цахим болгосон байх	1. Хүн амын бүртгэлийг цахимжуулж, шилжилт хөдөлгөөнийг жилд 2 удаа бүртгэсэн бол- 5 оноо 2. Хүн амын бүртгэлийг цахимжуулж, шилжилт хөдөлгөөнийг бүртгээгүй бол- 0 оноо	5 оноо
		Статистик мэдээг тайлант хугацаанд үнэн зөв гарган, дүн шинжилгээ хийж олон нийтэд мэдээллэсэн байх	1. Сар бүрийн статистик мэдээ гаргадаг бол-1 оноо 2. Тайлан, мэдээллийн үнэн зөв байдал- 2 оноо 3. Дүн шинжилгээ хийсэн бол -1 оноо 4. Олон нийтэд мэдээлсэн байдал-1 оноо	5 оноо
4	Санхүүгийн үйл ажиллага	Мэргэжлийн байгууллагын санхүүгийн хяналт шалгалтандаа хамрагдсан байдал	Зөрчилгүй бол -5 оноо Зөрчилтэй бол- 0 оноо	5 оноо

		Хөрөнгө оруулалтын бүртгэл, ашиглалт, хамгаалалтын талаар арга хэмжээ хэрэгжүүлсэн байдал	1. Аймаг, нийслэлийн өмчийн харилцааны газартай хийсэн гэрээний дүн- 2 оноо 2. Төвийн хөрөнгийг бүртгэж жагсаалт гаргасан, хөрөнгө ашиглалтын тооллого 2 удаа хийж, дотоод хяналттай, зөрчилгүй бол -2 оноо 4. Төсөл хөтөлбөр, хандиваар ирсэн хөрөнгийг үндсэн хөрөнгөд бүртгэж, ашиглаж байгаабол -1 оноо	5 оноо
		Санхүүгийн мэдээ тайланг хугацаанд нь үнэн зөв өгсөн байх	Хугацаанд нь өгсөн бол -5 оноо Хугацаанд нь өгөөгүй бол- 0 оноо	5 оноо
5	Баримт бичгийн стандарт мөрдөлт	Албан бичиг хэргийн хөтлөлт	1. Тушаал шийдвэр, баримт бичгийн боловсруулалт-2 оноо 2. Тушаал шийдвэр, баримт бичгийн хөтлөлт -1 оноо 3. Шийдвэрлэлт- 1 оноо 4. Архивын бичиг хэргийн бүрдүүлэлт, хадгалалт – 1 оноо	5 оноо
6	Удирдлагын манлайлал	Төвийн даргын манлайлал, удирдан зохион байгуулалт	1. Манлайлайх, удирдан зохион байгуулах ур чадвар- 2 оноо 2. Багаар ажиллах чадвар- 1 оноо 3. Ёс зүй, харилцаа хандлага- 1 оноо 4. Дотоодын хяналт хийж, түүний мөрөөр арга хэмжээ авсан бол- 2 оноо 5. Хамт олны үнэлгээ-1 оноо 6. Санхүү, үйл ажиллагааны ил тод байдлыг хангасан бол- 1 оноо 7. Цаг ашиглалт- 1 оноо 8. Тайлант хугацаанд санал, гомдол гараагүй бол – 1 оноо Хэрэв санал, гомдол гарсан бол гарсан гомдол нь үндэслэлтэй, нотлогдсон бол гомдлын тоогоор 1 оноо хасах	10 оноо

Хоёр. Эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээ- 165 оноо

1 Эрүүл мэндийн үндсэн үзүүлэлт	Үйлчлэх хүрээний хүн амд хүрч үйлчилсэн байдал	1. Эрүүл өрхөд жилд 1 удаа мэдээлэл хүргэсэн хувь 70-аас доошгүй бол – 1 оноо 2. Бага өртөмхий өрхийн иргэдэд жилд 1 удаа мэдээлэл хүргэж, тусlamж үзүүлсэн хувь 80-аас доошгүй бол -2 оноо 3. Өртөмхий өрхийн иргэдийг жилд 2 удаа үзлэг хийж, тусlamж үйлчилгээ үзүүлсэн хувь 100-аас багагүй бол – 2 оноо	5 оноо
	0-1 насны хүүхдийн эндэгдлийн түвшин	1. Эндэгдэлгүй бол - 5 оноо 2. Аймаг, нийслэлийн дундажаас доогуур бол - 3 оноо 3. Аймаг, нийслэлийн дундажаас их байвал-0 оноо	5 оноо
	1-5 хүртэл насны хүүхдийн эндэгдлийн түвшин	1. Эндэгдэлгүй бол - 5 оноо 2. Аймаг, нийслэлийн дундажаас доогуур бол - 3 оноо 3. Аймаг, нийслэлийн дундажаас их байвал-0 оноо	5 оноо
	Гэрийн төрөлт	1. Гараагүй бол - 5 оноо 2. Төвөөс хамааралтай гарсан бол тохиолдол бүрээс 1 оноо хасах 3. Төвөөс хамааралгүй бол - 4 оноо	5 оноо
	Эхийн эндэгдэл	1. Гараагүй бол- 5 оноо 2. Төвөөс хамааралтай гарсан тохиолдол бүрээс 1 оноо хасах 3. Төвөөс хамааралгүй бол - 4 оноо	5 оноо

	0-5 насны хүүхдийн гэрийн эргэлт, хяналт	<p>1. 2 хүртэлх сартай хүүхдийг 6-аас доошгүй удаа гэрээр 100% эргэсэн бол- 5 оноо/картын бичлэг, утсаар шалгах/</p> <p>2. 2 сараас 1 нас хүртэлх хүүхдийг сар бүр үзэж, 90-ээс доошгүй хувийг хянасан бол- 4 оноо /картын бичлэг, утсаар шалгах/</p> <p>3. 1-2 нас хүртэлх хүүхдийг улирал тутам үзэж, 80-аас доошгүй хувийг хянасан бол- 3 оноо/картын бичлэг, утсаар шалгах/</p> <p>4. 2-5 нас хүртэлх хүүхдийг хагас жил тутамд үзэж, 80-аас доошгүй хувийг хянасан бол- 3 оноо /картын бичлэг, утсаар шалгах/</p>	15 оноо
	Хяналт	<p>1. Эрүүл мэндийн 1-2-р бүлгийн иргэдийн тоо, 80-аас дээш хувьд нь мэдээлэл хүргэсэн бол – Зоноо</p> <p>2. Эрүүл мэндийн 3-р бүлгийн иргэдийн тоо, 90-ээс дээш хувьд нь тусlamж үйлчилгээ үзүүлсэн бол - 2 оноо</p> <p>3. Түүнээс 80-аас доошгүй хувьд нь идэвхтэй хяналт хийсэн - 3 оноо</p> <p>4. Эрүүл мэндийн 4-5-р бүлгийн иргэдийн тоо, гэрээр 100% хяналт хийсэн бол- 2 оноо</p> <p>5. Хөгжлийн бэрхшээлтэй, хэвтрийн иргэдийг сар бүр гэрээр үзэж, 100% хянасан бол- 5 оноо/картын бичлэг, утсаар шалгах/</p>	15 оноо
2	Тусlamж Үйлчилгээний чанар	<p>1. Тусlamж, үйлчилгээний чанар сайжруулах хөтөлбөрийн хэрэгжилт</p> <p>2. Хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн 90%-иас дээш бол – 3 оноо</p> <p>3. Тусlamж, үйлчилгээний чанар сайжруулах хөтөлбөргүй бол -0 оноо</p>	5 оноо

		<p>Чанарын дотоод хяналтын үйл ажиллагаа</p> <p>Тусlamж, үйлчилгээнд шинэ техник, багаж, арга хэрэгслэл ашиглах</p> <p>Үйлчлүүлэгчдэд ээлтэй орчин бүрдүүлсэн эсэх, байгууллагын соёл</p> <p>Сэтгэл ханамжийн үнэлэлт дүгнэлт</p>	<ol style="list-style-type: none"> Дотоод хяналт хийх тушаал, төлөвлөгөө, хуудастай бол - 2 оноо Тусlamж, үйлчилгээний чиглэл бүрт дотоод хяналтын хуудсаар эмч, сувилагчдыгүнэлдэг бол-2 оноо Үнэлгээний үр дүнгээр ажил зохион байгуулж хэрэгжүүлсэн бол-1 оноо Алдаа зөрчлийн бүртгэл тогтмол хөтөлдөг бол – 3 оноо Сайн туршлагыг бүртгэж нэвтрүүлсэн бол- 2 оноо <ol style="list-style-type: none"> Багаж, тоног төхөөрөмжийн ашиглалт -2 оноо Тусlamж, үйлчилгээг өргөжүүлсэн бол -2 оноо Чанар сайжруулах арга хэрэгсэл нэвтрүүлсэн бол -1 оноо <ol style="list-style-type: none"> Ээлтэй, аюулгүй орчин бүрдүүлсэн бол -2 оноо Хөтчийн үйлчилгээтэй бол -2 оноо Байгууллагын соёл тогтмолжсон бол /хувцаслалт, харьцаа хандлага/- 1 оноо <ol style="list-style-type: none"> Сэтгэл ханамжийн судалгааг сар бүр 30 иргэнээс авч, үр дүнгийн мөрөөр арга хэмжээ авсан бол - 2 оноо Мэдээллийн ил тод байдал - 1 оноо Тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зорилгоор судалгаа авч ажилласан бол- 2 оноо 	<p>10 оноо</p>  <p>5 оноо</p> <p>5 оноо</p> <p>5 оноо</p> <p>5 оноо</p>
3	Урьдчилан сэргийлэлт	Хүн амын дунд урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулах	<ol style="list-style-type: none"> Умайн хүзүү, хөхний хавдрын эрт илрүүлгийн үзлэгт хамрагдсан хувь 60%-иас дээш бол -2 оноо Чихрийн шижин, цусны даралт ихсэлт өвчний эрт илрүүлгийн үзлэг 30%-иас дээш бол -2 оноо Хүн амд чиглэсэн урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулж, үр дүнг тооцсон бол - 1 оноо 	5 оноо

4	Хүүхдийн эрүүл мэндийн тусlamж үйлчилгээ	0-5 насны хүүхдэд үзүүлэх тусlamж, үйлчилгээ	<ol style="list-style-type: none"> 1. 5 хүртэлх насны хүүхдийг ХӨЦМ ашиглан үнэлж, дүгнэлт хийж ажилласан байдал -3 оноо 2. 5 хүртэлх насны хүүхдийн суурь өвчний илрүүлэлт 100%, эрүүлжилтийн хувь 60-аас доoshгүй бол -3 оноо 3. ХӨЦМ-ийн эм тарианы хангарт, нөөц бүрэн бол-1 оноо 4. Хүүхдийн үзлэгийн өрөө, тохижилт -1 оноо 5. 5 хүртэлх насны хүүхдийн гэрийн болон хоног болоогүй нас барагт гаргаагүй бол -2 оноо /гарсан бол тохиолдол бүрээс 1 оноо хасах/ 	10 оноо 
		Товтолт дархлаажуулалтын хамралт	<ol style="list-style-type: none"> 1. Хамралтын хувь 96% дээш бол-5 оноо 93%-95% бол - 4 оноо 90-93% бол - 3 оноо 90%-иас доош бол - 0 оноо 2. Дархлаажуулалтын цэг нээж, ажиллагаа тогтмолжсон байвал-3 оноо 3. Дархлаажуулалтын сувилагч бэлдсэн байвал -2 оноо 	10 оноо
5	Өсвөр насны хүүхдийн тусlamж үйлчилгээ		<ol style="list-style-type: none"> 1. Өсвөр насны хүүхдийн судалгаа, дүгнэлт хийж ажилласан бол -1 оноо 2. Өсвөр насны хүүхдийн урьдчилан сэргийлэх үзлэг 50%-аас доoshгүй бол- 2 оноо 3. Өсвөр насны хүүхдийн өвчлөлийн эрүүлжилт 30%-ас доoshгүй бол – 2 оноо 	5 оноо
6	Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн эрүүл мэнд	Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн тусlamж үйлчилгээ	<ol style="list-style-type: none"> 1. НҮНЭ-ийн судалгаа, шилжилт хөдөлгөөнд бүртгэл хийж ажилласан байдал -1 оноо 2. НҮНЭ –ийн өвчлөлийн судалгаа хийсэн бол -1 оноо 3. НҮНЭ-ийн урьдчилан сэргийлэлт 40%-аас доoshгүй бол- 2 оноо 4. НҮНЭ-ийг гэр бүл төлөвлөлтэд хамруулсан хувь 50-аас доoshгүй бол- 1 оноо 	10 оноо

			5. Нэг цэгийн үйлчилгээг нэвтрүүлсэн байдал- 5 оноо	
		Жирэмсэн эхийн хяналт	<p>1. Жирэмсэн эмэгтэйчүүдийн судалгаа, өвчлөлийн байдалд дүгнэлт хийсэн бол- 2 оноо</p> <p>2. Жирэмсэн эмэгтэйчүүдийг хоёр дугаар шатлалт илгээсэн тохиолдолд эмэгтэйчүүдийн эмчтэй хяналтыг картыг тулгасан байдал- 2 оноо</p> <p>3. Жирэмсний эрт үеийн хяналт 80%-иас дээш бол -2 оноо</p> <p>4. Төвд хянагдаж буй жирэмсэн эмэгтэйчүүдийн тоо, хувь, чанар -2 оноо /утас, хөтөч картын бичилт/</p> <p>5. Төрсний дараах эхийн хяналт 100% бол -2 оноо /утас, хөтөч, картын бичилт/</p>	10 оноо
		Эмзэг бүлгийн НҮНЭ-ийн хяналт	<p>1. Эмзэг бүлгийн эмэгтэйчүүдийн судалгаа, өвчлөлийн бүртгэлтэй бол- 2 оноо</p> <p>2. Эмзэг бүлгийн эмэгтэйчүүдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан байдал 80%-аас доошгүй бол -2 оноо</p> <p>3. Эмзэг бүлгийн эмэгтэйчүүдийг гэр бүл төлөвлөлтөд хамруулсан хувь 70% -иас доошгүй бол -1 оноо</p>	5 оноо
7	Ахмад настны эрүүл мэндийн тусламж үйлчилгээ	Ахмад настны эрүүл мэнд	<p>1. Ахмад настны судалгаа, өвчлөлийн бүртгэлтэй бол -1 оноо</p> <p>2. Ахмад настныгурьдчилан сэргийлэх үзлэгх хамруулсан байдал 70%-иас дээш бол – 2 оноо</p> <p>3. Ахмадуудын нас, бие бялдрын онцлогт тохирсон дасгал сургалт, чийрэгжүүлэлт, хөдөлгөөн хийлгэх хөтөлбөртэй бол- 2 оноо</p>	5 оноо

8	Яаралтай онцой байдлын тусlamж үйлчилгээ	Яаралтай тусlamж үйлчилгээ	1. Яаралтай тусlamж үзүүлсэн иргэдийн тоо, хувь, чанар – 2 оноо /яаралтай тусlamжийн хуудас/ 2. Яаралтай тусlamжинд шаардлагатай эм, тариа, техник хэрэгслэлийн хангамж -2 оноо 3. Яаралтай тусlamж үзүүлэх сургалтад хамрагдаж, дадлагажсан эмч, мэргэжилтнүүдийн тоо -1 оноо	5 оноо
		Гамшиг, онцгой байдлын үеийн тусlamж үйлчилгээ	1. Гамшгаас хамгаалах төлөвлөгөө гарган холбогдох байгууллага, албан тушаалтнаар батлуулсан бол – 2 оноо 2. Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийсэн бол - 2 оноо 3. Гамшиг, онцгой байдлын үеийн бэлэн байдлын хангалт-1 оноо	5 оноо
9	Сувилахуйн тусlamж үйлчилгээ	Сувилахуйн тусlamж үйлчилгээ	1. Сувилагчийн орон тоо бүрэн бол - 2 оноо 2.Хүүхдийн өсөлт, хөгжилтийг хэмжин, өсөлтийн хоцрогдолтой, тураалтай хүүхдэд сувилахуйн тусlamж үзүүлсэн тухай үнэлгээ дүгнэлттэй ажилласан- 2 оноо 3. Нийт сувилагч нарынур чадварыг дээшлүүлэх сургалтанд 100% хамруулсан бол- 2 оноо 4. Сувилахуйн тусlamж, үйлчилгээнд шинэ санаа, тэргүүн туршлага нэвтрүүлсэн байдал -2 оноо 5. Нярай, төрсөн эхийг гэрээр эргэж, эрүүл мэндийн 4-5 бүлгийн иргэд, ахмад настныгхөнгөвчлөх, нөхөн сэргээх тусlamж үйлчилгээг 100% үзүүлсэн бол- 2 оноо /бүртгэл, тэмдэглэгээ, карт, утас/	10 оноо

Гурав: Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ - 100 оноо

1	Эрүүл мэндийн эрсдэл тодорхойлох	Үйлчлэх хүрээний хүн амын эрүүл мэндийн байдалд тандалт хийх	1. Иргэдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх хүчин зүйлийн тандалтын судалгаа хийсэн бол /архи, тамхи, хорт зуршил, таргалалт, стресс г.м/ - 5 оноо 2. Хүн амын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх орчны судалгаа хийсэн бол – 5 оноо 3. Хүн амын өвчлөлийн байдалд дүн шинжилгээ хийсэн бол - 5 оноо	15 оноо
2		Хүн амын эрүүл мэндийн байдалд сөргөөр нөлөөлж байгаа хүчин зүйлийг арилгах талаар авсан арга хэмжээ, үр дүн	1. Хэрэгжүүлсэн ажлын тайлан, үр дүн -3 оноо 2. Асуудлыг шийдвэрлүүлэхээр хандсан баримт бичиг, шийдвэрлэлт-2 оноо	5 оноо
2	Эрүүл аж төрөх мэдлэг мэдээлэл олгох	Хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох	1. Эрүүл мэндийн боловсрол олгох сургалтын төлөвлөгөөний биелэлт 100% бол– 5 оноо 2. Эрүүл мэндийн боловсролынсургалтанд хамрагдсан иргэдийн тоо /нийт хүн амын 30%-иас дээш байх/- 5 оноо 3. Эрүүл мэндийн боловсрол олгохсургалтын дараа мэдлэг олсон иргэдийн тоо /сургалтанд хамрагдагсдын 10%-иас дээш байх/- 5 оноо 4. Эрүүл мэндийн боловсрол олгох сурталчилгааны төлөвлөгөөний биелэлт 100% бол – 5 оноо 5. Эрүүл мэндийн боловсрол олгох сурталчилгаанд хамрагдсан иргэдийн тоо /нийт хүн амын 50%-иас дээш байх /- 5 оноо	20 оноо

3	Хамтын ажиллагаа	<p>Хүн амын эрүүл мэндийг хамгаалахад иргэд, олон нийт, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажилласан байдал</p>	<p>1. Гэрээ байгуулж хамтарч ажилласан төрийн байгууллагын тоо, тайлан, үр дүн – 2 оноо</p> <p>2. Гэрээ байгуулж хамтарч ажилласан ТББ-ын тоо, тайлан, үр дүн-2 оноо</p> <p>3. Гэрээ байгуулж хамтарч ажилласан аж ахуйн нэгж байгууллагын тоо, тайлан, үр дүн -1 оноо</p>	5 оноо
4	Үндэсний хөтөлбөрийн хэрэгжицт	<p>Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн байдал</p>	<p>1. Халдварт өвчинеэс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт /төлөвлөгөө, тайлан/- 5 оноо</p> <p>2. Халдварт бус өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт /төлөвлөгөө, тайлан/ - 5 оноо</p> <p>3. Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт /төлөвлөгөө, тайлан/ – 5 оноо</p> <p>4. Осол гэмтэл, хүчирхийллээс сэргийлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт /төлөвлөгөө, тайлан/ – 5 оноо</p> <p>5. Элэг бүтэн Монгол хүн үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт/төлөвлөгөө, тайлан/- 5 оноо</p> <p>6. Хүүхдийн хөгжил хамгааллын үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт/төлөвлөгөө, тайлан/- 5 оноо</p>	30 оноо

5	Халдварт өвчний талаар хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	<p>1.Харьяа хүн амын дунд зонхилон тохиолдох халдварт өвчний судалгаа мэдээлэл – 1 оноо</p> <p>2.Халдварт өвчнийг бууруулах талаар хийж хэрэгжүүлсэн ажлын тайлан-1 оноо</p> <p>3.Халдварт өвчнийг эрт сэргэмжлүүлэх, хариу арга хэмжээний тандалт мэдээг цаг хугацаанд өгсөн байдал -1 оноо</p> <p>4.Харьяа хүн амын дунд халдварт өвчний давтамж, тархалтанд тандалт хийсэн байдал -1 оноо</p> <p>5.Цочмог халдварт өвчний үед авсан арга хэмжээ, голомтод ажилласан байдал -1оноо</p>	5 оноо	
	Халдварт өвчний үед үзүүлэх тусламж үйлчилгээ	<p>1.Аймаг, дүүргийн түвшинд шинээр илэрсэн сүрьеэ өвчнөөс ΘЭМТ -н илрүүлсэн хувь 17 хувиас доошгүй байвал- 2 оноо</p> <p>2. Аймаг, дүүргийн түвшинд илэрсэн сүрьеэтэй өвчтөний ΘЭМТ-д эмчлэгдсэн хувь 20 хувиас доошгүй, эмчилгээний амжилт 88 хувиас доошгүй байвал -! 2 оноо</p> <p>3. Хавьтлын урьдчилан сэргийлэх үзлэгийн хувь 90%-иас дээш бол -2 оноо</p> <p>4. Сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулсан байдал -2 оноо</p> <p>5. Тайлан мэдээ хөтлөлт тайлагналт сүрьеэгийн кабениттэй тулгасан, үнэн зөв хөтөлсөн, үр дүнг тооцсон бол -2 оноо</p>	10 оноо	
6	Халдварт өвчиний эрт сэргэмжлүүлэг хариу арга хэмжээ	Халдвар хяналтын багийн үйл ажиллагаа	<p>1. Халдварын сэргийлэлт, хяналтын баг байгуулсан бол-1 оноо</p> <p>2. Халдварын сэргийлэлт, хяналтын багийн ажлын төлөвлөгөө, хэрэгжилт-2 оноо</p> <p>3. Халдварын сэргийлэлт, хяналтын багийг сургаж дадлагажуулсан байдал -2 оноо</p>	5 оноо

		Эрүүл ахуй халдварт хамгааллын талаар	<p>1. Төвийн эрүүл ахуй, ариутгал, аюулгүй тарилгын нөхцөл бүрдүүлсэн бол- 2 оноо</p> <p>2. Хог хаягдлын менежменттэй бол- 1 оноо</p> <p>3. Эрүүл мэндийн ажилтнуудыг урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулж арга хэмжээ авсан бол- 1 оноо</p> <p>4. Эрүүл мэндийн ажилтны халдварт хамгааллыг сахих чиглэлээр тодорхой арга хэмжээ авсан байдал -1 оноо</p>	5 оноо
--	--	---------------------------------------	---	--------

Дөрөв. Нэмэлт урамшуулал- 10 оноо

1	Гамшиг, осол, нийтийг хамарсан өвчний үеийн	Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн тусламж, үйлчилгээ	<p>1. Нэмэлт дархлаажуулалтын үед ажилласан байдал- 2 оноо</p> <p>2. Халдварт өвчний дэгдэлтийн үед ажилласан байдал – 2 оноон</p> <p>3. Аян, компанийн ажлын үед ажилласан байдал- 1 оноо</p>	5 оноо
2	Шинэ ажил	Санаачлан хэрэгжүүлсэн ажил	Тухайн жилд үйлчлэгч, үйлчлүүлэгчид чиглэсэн онцлог, бүтээлч ажил хийсэн бол – 5 оноо	5 оноо